

БАТЛАВ

ГҮЙЦЭТГЭГЧ: "ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ"- ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

2024 оны 03 сарын 01 өдөр /Д.БЯМБАСҮРЭН/



БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ: "ЭЛСТА" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

2024 оны 02 сарын 29 өдөр



**ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар 9Х35/126/2024

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, Барилгын тухай хууль, Иргэний хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм"-ийг үндэслэн зураг төсөлд магадлал хийх ажлын хүрээнд захиалагч, гүйцэтгэгчтэй холбогдон гарах үүрэг, хариуцлагыг хангахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Нэг талаас Эрчим хүчний үндэсний төвийг төлөөлж ЗТМХ-ийн дарга Н.Болд (цаашид "гүйцэтгэгч" гэх) нөгөө талаас Магадлал хийлгэх хүсэлт гаргасан Зураг төслийн байгууллага "Элста" ХХК (цаашид "захиалагч" гэх) түүнийг төлөөлж захирал Ж.Амарсанаа нар (хамтад нь "талууд" гэх) Монгол улсын иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараах зүйлийг харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

1.3. Энэхүү магадлал хийх зураг төсөл нь "Элста" ХХК-ийн боловсруулсан Улаанбаатар хот. СХД 24-р хороо. 3-р хэсэг. Зээлийн 36, 37-р гудамж гэр хорооллын гадна гэрэлтүүлгийн ажлын зураг, Улаанбаатар хот. СХД 7-р хороо. 7-р хэсэг. "Хилчин" хотхоны орон сууц хоорондох автозамын гадна гэрэлтүүлгийн ажлын зураг, Улаанбаатар хот. СХД 25-р хороо. Зүүн салаа 1,4,7-8-р. Хайрханы 1-р гудамж. Гудамжны гадна гэрэлтүүлгийн ажлын зураг төсөлд магадлал хийх ажил болно.

**Зураг төслийн ажлын жишиг үнийн дүн: 19,500,880.00** төгрөг байна. Үнийн дүнд НӨАТ болон бусад холбогдох хураамж, зардлууд орсон болно. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журмын 5.5 дугаар зүйлийг үндэслэн тооцов.

инженер-геологийн гэрээний дүн 0, геодозийн хэмжилтийн гэрээний дүн 0 төгрөг хасаж тооцов.

*Улсын төсөв, ОНХС, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт/*

**Магадлалын ажлын төлбөр: 1,170,000.00** (нэг сая нэг зуун далан мянган төгрөг)

1.4. Зураг төсөлд гүйцэтгэгч нь захиалагчаас үе шаттайгаар хүлээлгэн өгсөн багц зураг тус бүрийн хувьд хүлээн авснаас хойш Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу зураг төсөлд магадлал хийж баталгаажуулахдаа магадлалын ажлыг нэгдүгээр үе шатанд ажлын 5 хоног, хоёрдугаар үе шатанд ажлын 10 хоногт хийж гүйцэтгэхийг хуанлийн 21 хоногт багтаан магадлал хийх ажлыг хамтран зохион байгуулахаар харилцан тохиролцов;

1.5. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлыг зохион байгуулах, магадлал хийлгэх **ажлын хөлсийг** захиалагч нь тус төвийн **Хаан банк /5134241596/** тоот дансанд гэрээний хугацаанд багтаан шилжүүлсэн байна;


**Хоёр. Гүйцэтгэгчийн эрх**

2.1. Монгол улсын Эрчим хүчний сайдын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 188 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу захиалагчаас тухайн ажилд шаардагдах материал, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг энэ гэрээнд хавсаргасны дагуу гаргуулж авах;

2.2. Шаардлага хангаагүй зураг төслийн баримт бичгийн бүрдлийг захиалагчид албан тоотоор хариу өгөх;

**Гурав. Гүйцэтгэгчийн үүрэг**

3.1. Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; 6.1.14 дахь заалт, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн 7 дугаар зүйл, Эрчим хүчний сайдын 2015 оны 188 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийж журмыг тус тус үндэслэн магадлал хийлгэх ажлыг зохион байгуулах;



3.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар хүсэлтийн дагуу гэрээний хугацааг хоёр тал хамтран тохиролцсоны үндсэн дээр сунгана;

**Дөрөв. Захиалагчийн эрх**

4.1. Захиалагч орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, эсвэл эксперт магадлалын ажлыг гүйцэтгэх боломжгүй бол ажлын 1 хоногийн дотор гүйцэтгэгчид мэдэгдэж, экспертийг дахин томилуулах санал оруулах;

4.2. Захиалагч орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлэх;

4.3. Гэрээнд заагдсан хугацаанд ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд хугацааг сунгах, үндэслэлийг гаргах;

**Тав. Захиалагчийн үүрэг**

5.1. Гэрээний хавсралт бүхий баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

5.2. Магадлалын ажилд шаардагдах хууль эрх зүйн баримт бичиг, материалыг тухай бүр цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;

5.3. Магадлалын дүгнэлтээр гарсан зарчмын санал, зөрчлийг барилга байгууламжийн зураг төслийг хянан нягталж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд багтаан залруулга, тодруулга тайлбарыг хийж гүйцэтгэсэн байх;

5.4. Энэхүү гэрээний 1.4-т заасан хугацаатай уялдуулан орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийн дагуу залруулга /засвар/-ыг 10 хоног<sup>1</sup> багтаан хийж дуусган тус төвийн гэрээ хийсэн мэргэжилтэнд хүргүүлсэн байх;

**Зургаа. Хүлээх хариуцлага**

6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй бол зохих тал Монгол улсын шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ;

6.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар гэрээг сунгавал тухай бүр тэмдэглэл хөтөлж, гэрээний биелэлтийг дүгнэсний дараа сунгах эсэх асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.3. Зураг төсөл магадлалын ажил гүйцэтгэх явцад энэхүү гэрээний 5.4-т заасан хугацааг хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төслийн магадлалын ажлын төлбөрийн дүнгийн 0.4 хувиар алдангийг тооцно.

6.4. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх хугацаанд байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд нотлох баримтыг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ. Давагдашгүй хүчин зүйл арилсны дараа магадлал хийх ажлыг үргэлжлүүлэн хийх ба давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаа нь магадлал хийх хугацаанд тооцогдохгүй;

6.5. Энэхүү гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь "Монгол хэл" байна. Гэрээг талууд тус бүр нэг хувийг хадгалахаар хоёр хувь үйлдэнэ.


**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Гүйцэтгэгчийг төлөөлж:

СЭЗХ-ийн Дарга  /Б.Амараа/

ЗТМХ-ийн Дарга  /Н.Болд/

Гэрээ хариуцсан Мэргэжилтэн  /Д.Бямбажаргал/

ЗТМХ-ийн инженер  /А.Жандос/

Утас: 77114070, 77114030

Захиалагчийг төлөөлж:

"Элста" ХХК-ийн

захирал  /Ж.Амарсанаа/

Утас: 88117804

<sup>1</sup> Хугацааг хуанлийн өдрөөр тооцно.

